“ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ-МИНИЙ СОНГОЛТ” АЯН

Газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн баталсан “ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ-МИНИЙ СОНГОЛТ” нөлөөллийн аяны төлөвлөгөөний хүрээнд хийж хэрэгжүүлэх ажлын дагуу манай газрын хамт олон тус аянд нэгдэж байна.



Дам тамхидалтын хор уршиг нь хүүхдийн амьсгалын замын өвчний эрсдлийг 50 хувь нэмэгдүүлдэг. Мөн уушгины хөгжилд сөргөөр нөлөөлөх, харшлын өвчнийг нэмэгдүүлэх эрсдэлтэй. Тамхинаас татгалзан амьдралын эрүүл хэв маягийг хэвшүүлж, хайртай дотны хүмүүсээ хамгаалцгаая.



Хүүхдийн эрхийг хамгаалах нь зөвхөн хуулийн шаардлага биш, харин иргэн бүрийн ухамсартай үүрэг юм. Хүүхэд бүр өөрийн эрхээ бүрэн дүүрэн эдлэх боломжтой байх ёстой бөгөөд эдгээр эрхийн хэрэгжилтийг хангахын тулд бүх түвшний байгууллага, иргэн хамтран ажиллах нь нэн чухал юм.

Монгол Улсын Хүүхэд хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйл: Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үүргийг тусган зохицуулсан.



Хүүхдийн дэргэд архи, согтууруулах ундаа хэрэглэх нь тэдний сэтгэл зүй, өсөлт хөгжлийн орчинд сөргөөр нөлөөлдөг тул хуулиар хориглосон бөгөөд ийм үйлдэл гаргасан этгээдэд холбогдох хуульд заасан хариуцлага ногдуулдаг.

Согтууруулах ундаанаас — Татгалзъя!

